

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сонгинохайрхан дүүргийн Мичид ундрага ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/030/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

НТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал
Утас: Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn
Ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
менежер: С.Гантөгс
Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn
Аккаунт траст аудит ХХК-ийн захирал: П.Наранцэцэг
Цахим хаяг: acctrust.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг.Хараат бус аудиторын дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

Утас: 03-13 № 739
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРГИЙН МИЧИД УНДРАГА
ӨЭМТ-ИЙН ДАРГА Ч.СҮРЭНХҮҮ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Сонгинохайрхан дүүргийн Мичид ундрага ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Сонгинохайрхан дүүргийн Мичид ундрага ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийнх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нэг иргэнд ногдох санхүүжилт болон 4 төрлийн тусламж үйлчилгээний санхүүжилт 570.4 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргий эрүүл мэндийн төвөөс 4.1 сая төгрөг, хүүний орлого 158.5 мянган төгрөг, үнэ төлбөргүй орлого 410.7 мянган төгрөг нийт 575.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 631.6 сая төгрөгийн зардал гаргаж, 56.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна. Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

1426050861

С.Нарангуй /Dorjnamdar Sainjambal Narangui/

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/47 дугаар захирамжаар Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Мичид ундрага ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтийг 94.4 хувь буюу хангалттай гэж үнэлэн 2026 оны гэрээг нэг жилийн хугацаатай байгуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

Хоёр.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	5,462,153.89	1,385,845.22
1.1.4	Бусад авлага	29,518,181.21	7,888,847.20
1.1.6	Бараа материал	49,722,664.25	53,642,455.24
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	84,702,999.35	62,917,147.66
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	98,102,742.34	89,846,100.36
1.2.2	Биет бус хөрөнгө	1,320,000.00	1,017,500.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	99,422,742.34	90,863,600.36
1.3	НИЙТ ХӨРӨНГӨ	184,125,741.69	153,780,748.02
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	-	8,192,050.00
2.1.1.3	Татварын өр	-	10,614,036.80
2.1.1.4	НДШ-ийн өглөг		7,179,731.72
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,464,581.65	
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,464,581.65	25,985,818.52
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,464,581.65	25,985,818.52
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	81,799,711.00	81,799,711.00
2.3.2	Хувийн өмч	19,200.00	19,200.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	961,733.95	961,733.95
2.3.9	Хуримтлагдсан ашиг	98,880,515.09	45,014,284.55
2.3.20	Эздийн өмчийн дүн	181,661,160.04	127,794,929.50
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	184,125,741.69	153,780,748.02

Сонгинохайрхан дүүргийн Мичид ундрага ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	571,411,437.29	570,432,145.00
3	Борлуулалтын өртөг		
4	Нийт ашиг (алдагдал)	571,411,437.29	570,432,145.00
5	Түрээсийн орлого	-	
6	Хүүгийн орлого	267,936.75	158,463.47
7	Ногдол ашгийн орлого		
8	Үнэ төлбөргүй орлого		410,728.00
9	Бусад орлого	20,373,236.00	4,069,600.00
11	Ерөнхий ба удирдлагын зардал	574,347,181.92	631,576,740.46
15	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	100,000.00	-
18	Бусад ашиг (алдагдал)	(675,000.00)	-
19	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	17,130,428.12	(56,505,803.99)
20	Орлогын татварын зардал	-	
21	Татварын дараах ашиг (алдагдал)	17,130,428.12	(56,505,803.99)
23	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	17,130,428.12	(56,505,803.99)
28	Орлогын нийт дүн	17,130,428.12	(56,505,803.99)

Сонгинохайрхан дүүргийн Мичид ундрага ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

						/төгрөгөөр/
Д/Д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	81,826,300.00	2,910,600.00		78,820,497.97	163,557,397.97
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	(4,989.00)	(2,910,600.00)	961,733.95	2,929,589.00	975,733.95
3	Залруулсан үлдэгдэл	81,821,311.00	-	961,733.95	81,750,086.97	164,533,131.92
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				17,130,428.12	17,130,428.12
5	Бусад дэлгэрэнгүй орлого	(2,400.00)				(2,400.00)
9	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	81,818,911.00	-	961,733.95	98,880,515.09	181,661,160.04
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				2,639,573.45	2,639,573.45
11	Залруулсан үлдэгдэл	81,818,911.00	-	961,733.95	101,520,088.54	184,300,733.49
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(56,505,803.99)	(56,505,803.99)
	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	81,818,911.00	-	961,733.95	45,014,284.55	127,794,929.50

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	579,060,659.83	571,221,361.27
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	52,316,550.00	
1.1.2	Хүүний орлого	267,936.75	158,463.47
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	490,118,018.09	562,543,297.80
1.1.6	Бусад мөнгөн орлого	36,358,154.99	8,519,600.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	567,333,815.33	561,990,169.94
1.2.1	Ажиллагчдад төлсөн	344,669,644.00	283,737,129.62
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	74,016,012.39	40,161,371.29
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	46,175,265.95	63,373,874.36
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	8,248,821.82	10,495,130.35
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		1,500,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	38,291,629.72	21,846,862.75
1.2.9	Бусад мөнгөн зарлага	55,932,441.45	140,875,801.57
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	11,726,844.50	9,231,191.33
2.00	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	16,550,000.00	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	100,000.00	
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	16,450,000.00	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,997,495.00	13,307,500.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,997,495.00	13,307,500.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	9,552,505.00	(13,307,500.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,800.00	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	4,800.00	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	16,450,000.00	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	16,450,000.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(16,445,200.00)	-
4	Валютын ханшийн зөрүү		
5.00	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,834,149.50	(4,076,308.67)
6.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	628,004.39	5,462,153.89
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,462,153.89	1,385,845.22

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 1,140.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 4,173.7 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/, НТАГ-2026/030/НА-СТА-ОНӨҮГ

Сонгинохайрхан дүүргийн Жаргал өлзий ӨЭМТ-ийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Дөрөв.Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өмчийн өөрчлөлтийн тайлангийн эзэмшигчдийн бусад хэсгийг 1,140.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	1,140.9	-	-	1	1,140.9	1	1,140.9	-	-	-	-
	Дүн	1	1,140.9	-	-	1	1,140.9	1	1,140.9	-	-	-	-

4.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
								Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Татварын цахим системд тайлант онд худалдан авсан 4,173.7 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний и баримт бүртгэгдээгүй байна.	1	4,173.7	-	-	-	-	1	4,173.7	-	-	-	-
	Дүн	1	4,173.7	-	-	-	-	1	4,173.7	-	-	-	-